



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/22


Өмнөдэлгэр сум

Хүүхэд хамгааллын бодлого батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3, 30.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/110 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг байгууллагын “Эцэг эхийн зөвлөл” болон нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.



ДАРГА

Л.БАЯРМАА

Засаг даргын Тамгын газрын даргын
2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн
А/23 дугаар тушаалын хавсралт

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Байгууллага нь Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын жишиг бодлого, Эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасны дагуу ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн дотоод журамд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.

Хоёр. Зорилго

2.1 Ажилтан, албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орох, гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалахад хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлж, байгууллагын нөөц байгууллагын онцлогт нийцүүлэн хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлж ажиллана.

Гурав. Хамрах хүрээ

3.1. Энэхүү баримт бичиг нь байгууллагын бүх үндсэн болон гэрээт ажилтан, албан хаагч, хамтран ажиллах Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хэнтий шинэс сум дундын ойн ангийн ажилтнуудад хамаарна.

Дөрөв. Үндсэн зарчим

4.1. Хүүхдийн эрх, язгуур эрх ашиг, тэдний аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн үзнэ.

4.2. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй.

4.3. Аливаа үйл ажиллагаанд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл, үл хайхрах байдал, осол гэмтэлд өртүүлж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх

Тав. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

Хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- 5.1. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах
- 5.2. Зөрчлийг мэдээлэх, мэдээлэл хүлээн авах
- 5.3. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд холбон зуучлах
- 5.1. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд:
 - 5.1.1 Сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ

5.1.1.1. Ажилтнуудад хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцааны чиглэлээр сургалт явуулна.

5.1.1.2. Хүүхэд хамгаалал хүүхдийн эрхийн талаарх хууль эрх зүйн баримт бичгийн талаар мэдээлэл өгч, сургалт явуулна.

5.1.1.3. Хүүхдэд ээлтэй байгууллага байх талаар хамт олонтойгоо нээлттэй ярилцаж, хүүхэдтэй холбоотой аливаа зөрчлийг мэдээлэх соёл төлөвшүүлнэ. Тухайлбал:

- Аливаа баяр ёслол, тэмдэглэлт өдөр, олон нийтийг хамарсан арга хэмжээн дээр хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр байршуулахгүй байх
- Хүүхдийн хөгжих, эрүүл аюулгүй орчин бүрдүүлж, хараа хяналттай байхад анхаарч, байгууллагын дэргэдэх цэцэрлэг, өдөр өнжүүлэх төв, хүүхдийн өрөө байгуулан, санаачилгатай ажиллах
- Жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй ажилтан, албан хаагч болон нярай, бага насны хүүхэдтэй үйлчлүүлэгчид ээлтэй, таатай орчин бүрдүүлж, хүүхэд хөхүүлэх, хуурайлах (живх солих), хооллох, амрах өрөөг бий болгох
- Сургуулийн өмнөх болон бага ангийн хүүхэдтэй ажилтан, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эх, хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай өрхийн гишүүнтэй ажилтан, өрх толгойлсон эцэг, эхийн ажиллах нөхцөлийг уян хатан болгож хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгуулж, мөрдүүлнэ.

5.1.2 Хүүхэд хамгааллын асуудлаар мэргэжлийн байгууллагуудаас мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа авч, хамтран ажиллана.

5.1.3 Байгууллагын ажил үйлчилгээ, үйл ажиллагаа нь хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүй эрсдэл байгаа эсэхэд тогтмол үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах, арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

5.1.4 Өөрийн ажил үйлчилгээ, үйл ажиллагаандаа хүүхдийн эрхийг ханган аюулгүй орчныг бүрдүүлнэ.

5.2. Зөрчлийг мэдээлэх, мэдээлэл хүлээн авах арга хэмжээний хүрээнд:

5.2.1 Ажилтан бүр хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл, мөлжлөгийн талаар байгууллагын удирдлага, Хүүхэд хамгааллын хамтарсан баг, эцэг эхийн зөвлөлд мэдээлэх үүрэгтэй.

5.2.2 Байгууллагын ажилтан болон бусад хүмүүс хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг зөрчсөн болон зөрчсөн байж болзошгүй үйлдэл, зан үйлийн талаар мэдээлнэ.

5.2.3 Байгууллага дээр болон байгууллагаас явуулж буй үйл ажиллагааны үеэр хүүхэд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдалд өртсөн буюу өртсөн байж болзошгүй талаар мэдээлэх, хүлээн авах

5.2.4 Сум, багийн нутаг дэвсгэр, тодорхой газар хүүхдийн аюулгүй байдал алдагдсан, хүүхэд хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн болон өртсөн байж болзошгүй талаар мэдээллийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу холбогдох байгууллагад мэдээлнэ.

5.2.5 Мэдээлэгчийн нууцлалыг хадгалан, мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангана.

5.3. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд холбон зуучлах арга хэмжээний хүрээнд:

5.3.1 Байгууллага нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээллийн мөрөөр ажиллахдаа хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах буюу холбон зуучилна.

5.3.1.1. Шуурхай үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээнд холбон зуучлахдаа уг үйл ажиллагааны улмаас хүүхдийг дахин хохирогч болгохгүй байхад онцгой анхааран ажиллана.

5.3.1.2. Бүх мэдээллийн нууцыг хадгалж, асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэнэ.

5.3.1.3. Мэдээллийг хүлээн авсан байгууллагын эцэг эхийн зөвлөл нь байгууллагын удирдлагатай зөвшилцөж, тухайн нөхцөлд тохируулан дараагийн алхмыг хэрэгжүүлнэ.

5.3.1.4. Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлсэн нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүүхдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд ханган, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана

5.3.2 Хэрэв тухайн асуудал нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол дараах арга хэмжээг авна:

5.3.2.1. Хуулийн байгууллага болон аймаг, сум, багийн эрх бүхий хүүхэд хамгааллын байгууллага, хамтарсан багт яаралтай мэдэгдэнэ.

5.3.2.2. Хуулийн байгууллага болон орон нутгийн эрх бүхий хүүхэд хамгааллын байгууллагаас нь хэргийн явцын болон хэрхэн шийдвэрлэсэн талаарх эцсийн мэдээллийг авдаг байх, шийдвэрлээгүй бол дараагийн шатны байгууллагад дахин мэдэгдэх

5.3.3 Хэрэв тухайн асуудал нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол дараах арга хэмжээг авна:

5.3.3.1. Буруутай этгээдийн асуудлыг байгууллагын дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

5.3.3.2. Хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх шаардлагатай бол аймаг, сум, багийн хүүхэд хамгааллын байгууллага болон мэргэжлийн байгууллагын үйлчилгээнд холбон зуучилна.

Зургаа. Ажилтнуудын ёс зүйн дүрэм

6.1. Байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагч бүр ажлын байр, гэр бүл, нийгмийн бүхий л орчинд зохисгүй зан үйл гаргахгүй байхад анхаарч, хүүхэд хамгааллын ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

Ажилтан		Байгууллага
Ёс зүйн дүрэмд	☒ Хүүхдийг цохих, зодох, тусгаарлах зэргээр бие махбодын хүчирхийлэл үйлдэх	☒ Байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг зөрчиж байгаа нь мэдэгдсэн, сэжиглэгдсэн боловч

заавал тусган хориглох зүйл	☒ Хүүхдийг гутаах, ичээх, доромжлох, дорд үзэх, нэр хоч өгөх, сэтгэл зүйн дарамт учруулах зэргээр сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх ☒ Хүүхэд, гэр бүлийн эсрэг бүх төрлийн хүчирхийл үйлдэх ☒ Бусдыг садар самуунд уруу татсан тоглоом тоглох, шалиг үг ярих ☒ Хүүхдийн дэргэд хараал хэлэх, бүдүүлэг үг хэрэглэх ☒ Хүүхдийг ялгаварлан харилцах ☒ Хүүхэд хүчирхийлэлд өртсөн, аюултай нөхцөл байдалд орсон тохиолдолд мэдээлэхгүй орхих ☒ Зохисгүй хувцаслах, бэлгийн дур сонирхол төрүүлэхүйц байдал гаргах ☒ Чанарын баталгаагүй, муудсан, хориглосон, чихэрлэг хоол хүнсээр хангах ☒ Хүүхдийн зураг, дүрс, мэдээллийг зөвшөөрөлгүй хувийн фэйсбүүк хуудас ба бусад хувийн нийгмийн сүлжээн дээр тавих ☒ Шөнийн цагаар эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүй хүүхдийг тээвэрлэх ☒ Цахим орчинд эцэг эхээс нь далдуур хүүхэдтэй харилцах	мэдээгүй мэт өнгөрөөх, нуун дарагдуулах ☒ Хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн, ажигласан, таамагласан боловч мэдээлэхгүй байх ☒ Хүүхдийг ямар нэгэн хөдөлмөрт хөлслөх. ☒ Ажилтнууд насанд хүрээгүй хүүхдээр өөрийн хүүхдийг асруулах, гэрийн үйлчлэгч хийлгэх, хувийн бизнестээ олон цагаар туслуулах ☒ Оройн 18 цагаас хойших арга хэмжээнд хүүхэд оролцуулах ☒ Эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүй хүүхдийг урлаг, спортын үйл ажиллагаанд оролцуулах ☒ Гамшиг осол, уй гашуу тохиолдсон үед хүүхэд, насанд хүрэгчдийн эмзэг байдалд мэдрэмжгүй хандах ☒ Эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийг ганцааранг нь машинаар авч явах ☒ Ёс заншил, шашны болон зан үйлийн хэлбэртэй үйл ажиллагаанд оролцуулах ☒ Зураг, мэдээллийг хувийн фэйсбүүк хуудас ба бусад хувийн нийгмийн сүлжээн дээр тавих ☒ Ажлын байр, хүүхдийн орчинд архи, тамхи мансууруулах эм бодис хэрэглэх
------------------------------------	--	--